

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах талаар:

Эрдэнэс ҮТП ХХК нь хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг ханган ажиллах талаар дараах төлөвлөлтийг хийж ажиллаж байна.

1. Эрдэнэс Монгол ХХК-ийн дунд хугацааны бодлого, зорилттой уялдсан, бодит шаардлагад нийцсэн оновчтой орон тоог бий болгож, хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллана. Энэ хүрээнд:
 - 1.1.Хууль эрх зүйн хүрээнд МУ-ын үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомжууд, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг хүний нөөцийн үйл ажиллагаанд дагаж мөрдөнө. Компанийн Ёс зүйн дүрэм, Нууцын журмыг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.
 - 1.2.Удирдах ажилтны манлайллыг хэрэгжүүлж, ёс зүйн зарчмын шаардлагыг тавьж эрх мэдэл хариуцлагын тогтолцоог сайжруулна. Удирдлагын манлайлал, ёс зүйн сургалтад нэгжийн менежерүүдийг үе шаттай хамруулна.
 - 1.3.Ажилтныг албан тушаал дэвшүүлэх, шинээр ажилд авахдаа хандлага ур чадвар, мэргэшлийн бэлтгэгдсэн байдал, ёс зүйг эрхэмлэнэ.
 - 1.4.Хүний нөөцийн удирдлагын цахим программ нэвтрүүлэх боломж, нөхцөлийг судална. /Зарим төрийн болон аж ахуйн нэгжид хэрэглэж буй хүний нөөцийн удирдлагын программ, Able, epr, office 365 г.м/
2. Гүйцэтгэлийн үнэлгээг бодитой хэрэгжүүлж, цалин хөлстэй уялдуулах, шагнаж урамшуулах тогтолцоог бий болгоно. Энэ хүрээнд:
 - 2.1.Ижил төрлийн ажил үйлчилгээнд ижил төрлийн цалин хөлс олгоно.
 - 2.2.Ажилтны ажлын гүйцэтгэлийг бодитой зөв үнэлж, дүгнэх журам боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнгээр нь шагнаж урамшуулна.
3. Нийгмийн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд:
 - 3.1. Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулна.
 - 3.2. Компанийн ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд даатгуулна.
 - 3.3.Шинэ жил олон улсын хүүхдийн болон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалар өдөр, цагаан сар зэрэг тэмдэглэлт өдрүүдээр ажилтнуудын хүүхдүүд, эмэгтэй ажилтнуудад хүндэтгэл үзүүлнэ
4. Ажилтныг сургаж хөгжүүлнэ. Энэ хүрээнд:
 - 4.1. Ажилтны сургалтын хэрэгцээнд үндэслэж, ажилтнуудыг ажлын байранд болон богино, дунд хугацааны зорилтот сургалтуудад хамруулна.
 - 4.2.Гадаадын улс орны технологийн шинэ шийдэл, тэргүүн туршлагаас судлуулна.
 - 4.3."Шинэ ажилтны хөтөч" цахим гарын авлага бэлтгэж, чиглүүлэх сургалт зохион байгуулна.
 - 4.4."Мэдээллийн цаг" хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын техник технологийн хөгжлийн шинэ хандлага, шийдлүүд, тэдгээрийг хиймэл оюун ухаанд суурилан хөгжүүлэх бодит боломжууд зэрэг нийгэм эдийн засаг, соёл шинжлэх ухаан технологийн ололт амжилтын мэдээллүүдийг зохион байгуулна.